



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 10 өдөр

Дугаар 438

Улаанбаатар хот

Г Дотоодын сургалтыг зохион  
байгуулах тухай Г

Монгол Улсын Эрүүл Мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, 20.2.7 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. 2024 оны 9 дүгээр сард үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлэх тушаал шийдвэрийг танилцуулах, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдыг тасралтгүй сургах, мэдлэгийг нэмэгдүүлж, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгууларх сургалтын хуваарийг хавсралтаар баталсугай.
2. Хуваарийн дагуу сургалтыг зохион байгуулахдаа сургалтын удирдамжийг батлуулж, сургалтын өмнөх болон дараах мэдлэгийн тестийг авч дүгнэлт хийх, зохион байгуулсан сургалтыг тайланг тухай бүр гаргаж тайлагнаж ажиллахыг сургалт зохион байгуулсан ажилчдад үүрэг болгосугай.
3. Дотоодын сургалтанд хуваарийн дагуу бүрэн хамрагдахыг бүх ажилчдад үүрэг болгосугай
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөц, Дотоод хяналтын ажилтан (Г.Гантуяа)- нарт даалгасугай.

ДАРГА

Х.ГАНБАТ



Багахангай Эрүүл мэндийн төвийн даргын  
2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн  
1888 тушаалын хавсралт

## БАЙГУУЛЛАГЫН ДОТООДЫН СУРГАЛТЫГ ХУВААРЬ

### ЗОРИЛГО:

Байгууллагын ажилчдын тогтвортой байдлыг хангаж, ажилтныг ажлын байранд дадлагажуулан сургах, ажилчдын мэдлэгийг нэмэгдүүлж, ур чадварыг дээшлүүлэх, чадварлаг байх нөхцөлийг бүрдүүлэх, эмнэлгийн тусlamж үйлчилгээг чанартай хүргэх, холбогдох дээд шатны байгууллагаас гарсан тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангахад оршино.

### ХҮРЭХ ҮР ДҮН:

- Байгууллагын ажилчдад зориулсан дотоодын сургалтыг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллана.
- Сургалтыг зохион байгуулах хөтөлбөр, төлөвлөгөө нөхцөл байдалтай уялдуулан тухай бүр гаргах, үйл ажиллагааг тогтмолжуулсан байх
- Ажилчдын илтгэх, өөрийгөө илэрхийлэх ур чадварыг дээшлүүлэх
- Ажлын байранд хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар хяналтыг тавьж ажиллах.

### ЗОХИОН БАЙГУУЛАХ:

- Төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулах ажилтан 5-7 хоногийн өмнө сургалтын удирдамжийг боловсруулж байгууллагын даргаар батлуулна.
- Сургалтын материалыг бэлтгэх удирдах ажилтнаар 2-3 хоногийн өмнө хянуулсан байна.
- Сургалтаар олгох мэдлэгийн тестийг боловсруулсан байна.
- Мэдлэгийн тестийг сургалтын өмнө боон хойно гэж 2 удаа авч сургалтын үр дүнг тооцож тайланг тусгана.
- Зохион байгуулсан сургалтыг өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжүүлэхэд шаардлагатай зүйлсийг удирдлагад танилцуулах
- Сургалтын үр дүнг тооцож хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавина.
- Сургалтыг зохион байгуулсны дараа дараа 7 хоногийн даваа гариг гэхэд удирдамж, бүртгэл, сургалтын материал, мэдлэгийн тест, хийсэн ажлын товч тайлан зурагтай баталгаажуулан Хүний нөөц, дотоод хяналтын ажилтанд хүлээлгэн өгнө.

**ДОТООДЫН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ**

№	Сургалтын нэр	Сургалт зохион байгуулах огноо	Сургалтыг зохион байгуулах ажилтан
1.	Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартын үйлчлүүлэгчтэй харилцах сэдэв	2024.09.12	Статистикч О.Удвал
2.	Сувилахуйн тусламж үйлчилгээнд баримтлах хэм хэмжээ		
3.	Эмч, эмнэлгийн ажилчдын хоорондын харьцаа хандлага ёс зүйн хэм хэмжээ	2024.09.19	Сувилагч Г.Энхцэцэг
4.	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/352 дугаар тушаал буюу “Үйлчлүүлэгчийн зөв танин тодруулах журам”	2024.09.26	Сувилагч Ч.Оюунжаргал

- Цагийн үеийн холбогдолтой мэдээлэл хүргэх сургалтуудыг тухай бүр зарлаж зохион байгуулна.
- Дотоодын сургалтанд ажилчид удирдамжийн дагуу бүрэн хамрагдана.